

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын нэр:	Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал		
Огноо:	2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 11:00-14:20	Уулзалтын газар:	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн хурлын заал
Хурлын дарга:	Жанчивдоржийн Баасандорж, МЦХ ХК-ийн Инновац, бизнес хөгжлийн газрын захирал		
Тооллогын комисс:	Дарга: Т.Бямбасүрэн, Бодлого төлөвлөлтийн албаны ерөнхий менежер, Гишүүд: Ц.Нармандах, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер, Э.Булганчимэг, ИБХГ-ын техник төлөвлөлтийн мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Дарга: Ч.Цогтгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын захирал Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Отгончимэг, Удирдлага хүний нөөцийн газрын мэргэжилтэн		
Ирц:	Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276 ширхэг. Үүнээс нийт 24,503,286 ширхэг саналын эрх бүхий 26 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.72%		

ХЭЛЭЛЦСЭН нь:

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай, үүнд:
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай
 - Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах тухай
- Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай;
- ТУЗ болон түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний аргачлал, загвар батлах тухай;

СОНССОН нь:

Т.Бямбасүрэн, Тооллогын комиссын дарга: 1. Компанийн тухай хуулийн 69.1-д “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно”; 2. МЦХ ХК-ийн дүрмийн 7.12-д “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 61-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 24,503,286 ширхэг хувьцаа эзэмшиж буй 26 хувьцаа эзэмшигч ирж 94.72 хувийн ирцтэй байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

Ж.Баасандорж, хурлын дарга: Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 211 дүгээр хурлын 04 дүгээр тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг зарласан. Уг хурлын шийдвэрээр 2025 оны 4

сарын 30-ны энэ өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна. Ирц бүрдсэн тул хурлыг эхлүүлэе.

Хурлын дарга Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулж, хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлаар танилцуулга хийх илтгэгчдийг индэрт урьж, танилцуулга хийлээ. Үүнд:

Нэгдүгээр хэлэлцэх асуудлаар

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;

Хэлэлцэх асуудлаар компанийн 2023 оны үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн тайлан болон компанийн нэмэлт хувьцаа гаргах явц, 2024 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний талаар МЦХ-ийн Гүйцэтгэх захирал Б.Чинбат, компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Н.Мягмарсүрэн, тайлангийн талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа нар тус тус танилцууллаа.

Хоёрдугаар хэлэлцэх асуудлаар

2. Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай

Хэлэлцэх асуудлаар ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг МЦХ ХК-ийн Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Н.Мягмарсүрэн танилцууллаа.

Гуравдугаар хэлэлцэх асуудлаар

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай
Хэлэлцэх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ танилцууллаа.

Дөрөвдүгээр хэлэлцэх асуудлаар

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Хэлэлцэх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны тогтоол, нэр дэвшигчдийн танилцуулгыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Тавдугаар хэлэлцэх асуудлаар

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай;

Хэлэлцэх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийн төслийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Зургаадугаар хэлэлцэх асуудлаар

6. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний аргачлал, загвар батлах тухай;

Хэлэлцэх асуудлаар ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга С.Цолмон ТУЗ-ийн үнэлгээний талаар танилцууллаа.

С.Цолмон, ТУЗ-ийн хараат бус гишүүн: Санхүүгийн зохицуулах хорооноос хувьцаат компаниудын засаглалыг үнэлдэг болоод нэлээн хэдэн жил болсон байгаа. Үүнд

компаниудын кодексын хэрэгжилтийг үнэлдэг. 2023 онд манай компани 84.7 гэдэг үнэлгээтэйгээр 10 дугаар байрт эрэмбэлэгдэж байсан. 2024 онд энэ үнэлгээ сайжирсан. Нийт хувьцаат компаниуд дотор МЦХ ХК-ийн засаглалын үнэлгээ 95.4 хувь болж 3 дугаар байрт эрэмбэлэгдсэн. Компанийн засаглал сайжирсныг харуулж байгаа. Тэр дундаа компанийн гүйцэтгэх засаглал ТУЗ болон, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаа ямар түвшинд сайжирсныг харуулж байгаа. Төрийн болон, төрийн өмчийн оролцоотой компаниудаас засаглалын үнэлгээгээрээ хамгийн өндөр үнэлгээ авсан. Тэгэхээр бид компанийн засаглалын үнэлгээгээрээ нийт хувьцаат компани дотроо сайн засаглалтай болсон байна. Цаашид бид ялангуяа ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг илүү сайжруулж, хуульд нийцсэн үйл ажиллагааг явуулдаг, компанийн засаглалын кодекс болон олон улсын компанийн засаглалын зарчимд нийцсэн байдлаар илүү өгөөжтэй ажилладаг болоход өөрийн үнэлгээний аргачлал хэрэг болж байгаа. Үүнд эрхзүйн үндэслэл нь Компанийн тухай хуулийн 84.5.4 дээр Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгдөг байна гэж заасан байдаг мөн компанийн засаглалын кодексын 1.3-д ТУЗ, хороодын дарга гишүүдийн гүйцэтгэлийн үнэлгээг жил бүр тайлагнадаг байх ёстой гэж заасан байдаг. ТУЗ-ийн даргын үнэлгээг хараат бус гишүүн үнэлнэ гэж заасан байгаа. Олон улсын компанийн засаглалын зарчмын 3.1.3, 4.6.2-д ТУЗ-ийн үнэлгээний системийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ёстой гэж заасан байдаг. Тэгэхээр бид олон улсын сайн засаглалтай компанийн түвшинд хүрч очихын тулд зайлшгүй өөрсдийгөө үнэлэх, үнэлгээдээ тулгуурлан дараа жилүүдэд тухайн хороод илүү сайн ажиллахын тулд юуг илүү анхаарч ажиллах вэ, ТУЗ олон улсын жишиг нийцсэн ялангуяа хувьцаат компанийн ТУЗ яаж ажиллах ёстой вэ юуг хийх ёстой вэ гэдэг зүйлүүдээ бодитой үнэлээд, алдаа оноогоо дүгнээд цаашдаа үйл ажиллагаа сайжруулаад үнэлгээг хийх нь эцэстээ удирдлагын шийдвэрийг оновчтой болгох, хяналт шалгалтыг илүү сайжруулах, нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах, компанийн урт хугацааны стратегийг илүү оновчтой үр өгөөжтэй төлөвлөж хэрэгжүүлдэг болох, үр ашгийг дээшлүүлэх, үнэ цэнийг нэмэгдүүлэхтэй холбоотой зорилтуудыг дэвшүүлж үнэлгээний аргачлалыг хийсэн. Энэхүү үнэлгээний аргачлалыг тогтмол хийдэг болсноор компани олон талын ач холбогдлуудтай болно. Үүнд: Компанийн засаглалыг сайжирна. Хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна, удирдлагын шийдвэрийг оновчтой болгоход хувь нэмрээ оруулах юм. Эрсдэлийн удирдлагын менежментийг сайжруулахад үр ашигаа өгөх боломжтой гэх мэд үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөл болон, хороодын түвшинд Нэр дэвшүүлэх хорооноос боловсруулсан. ТУЗ-ийн үнэлгээний хувьд 10 бүлэг нийт 50 асуултаас бүрдэж байгаа. Үнэлгээ тус бүрийг шаардлага бүрэн хангаж байгаа, хэсэгчлэн хангаж байгаа, огт хангахгүй байгаа гэдэг байдлаар оноожуулна. Эцсийн дүн 100 онооноос хэдэн оноо авч байна гээд хувиар гарна. Энэ ТУЗ-ийн үнэлгээний аргачлал шиг хороодын үнэлгээг Компанийн тухай хууль, засаглалын кодекс, олон улсын компанийн засаглалын зарчмуудад нийцүүлээд үндсэн чиг үүрэг тус бүрээр нь хороод дээр нарийвчилсан үнэлгээний аргачлалыг боловсруулсан. Мөн ижил доторх шалгуур үзүүлэлтүүд нь бүрэн хангагдсан эсэхээс хамааран хэмжүүрүүд нь өөр байгаа. Эцэст нь нэгдсэн үнэлгээ нь 90-100 байвал маш сайн, 80-89 оноотой бол сайн, 70-79 бол дунд, 50-69 хангалтгүй, 49 хүртэл оноо авбал ТУЗ-ийн үйл ажиллагаа маш муу, сайжруулах шаардлагатай байна гэсэн үнэлгээ гарч ирэх юм.

Ж.Баасандорж, хурлын дарга: Танилцуулагдсан асуудлуудтай холбоотой асуулт, хариулт. Асуулттай хүмүүс гараа өргөөд, микрофон аваад асуулна уу.

Асуулт хариулт, санал:

Ганболд: 1. Нэмэлт хувьцаа гаргах асуудал зогссон гэсэн үг үү. Цаашдаа үргэлжлэх үү. 2. Горимын санал, хувьцаа эзэмшигчдийн материал дээр байгаа зүйлүүдийг бүгдийг нь нэг бүрчлэн уншаад байлгүй, материал харах боломжтой зүйл дээр цаг хэмнэх байх. Цаашдын хурлууд дээрээ анхаарахгүй юу.

Б.Чинбат, Гүйцэтгэх захирал: Нэмэлт хувьцаа гаргах асуудлыг зогссон гэж ойлгож болохгүй. Зарим зүйл заалтыг их хурал дээр засахаар засгийн түвшинд яригдаж байгаа гэж ойлгож байгаа. Ер нь бол зогссон биш, түр хойшилсон гэж ойлгосон зөв болов уу гэж бодож байна.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Үйл ажиллагааны тайланд дотоод аудитын тайлан ТУЗ-ийн дэргэдэх аудит уу, компанийн дотоод аудит уу. Технологийн чанартай юм асууя. Шугамын гэмтлийн засалтын дундаж хугацаа 12 цаг гэж заасан байна. Энэ нийт шугамын гэмтлийн хяналтын хугацаа юм уу, эсвэл хяналт хэтэрсэн цэгийн хяналтын хугацаа юм уу. Манай компанид хяналтын хугацаа чухал, үйлчилгээ авах сонирхолтой болгох үзүүлэлт. Энэ хугацааг яаж тогтоосон бэ, энэ хугацаа их юм уу, бага юм уу. Үүнийг дотоод аудит юу гэж үзээд тайландаа тусгасан юм бэ. Үүнийг тайланд тусгах хэрэг байсан юм уу, хэтэрхий нийтлэг, дотоод асуудал. Fiber to the home гэдэг сүлжээг бид нэвтрүүлээд олон жил болж байна. Тайланд дээр 2021 оноос хойш энэ сүлжээг оруулсан тоон график байна. Энэ дээр 2024 онд 4,314 гэж бичсэн байна. Энэ ямар хэмжээг илэрхийлсэн тоо вэ. Цэгийн тоо юу, сүлжээ оруулсан объектын тоо юу, ONT төхөөрөмж суурилуулсан тоо юу. Сүлжээ 21 аймгийн төвд хүрсэн нь ойлгомжтой. Сүлжээ 47 сумдад хүрсэн гэж бичсэн байна. Манай компанийн бодит байдал хүрсэн сумын тоо юу, тайлант хугацаанд сүлжээг оруулсан тоо юу? Яагаад асуугаад байна гэвэл би Барилга, хот байгуулалтын яамны сүлжээний зураг төсөл хийдэг газрын магадлал хийдэг хүн. Зураг төсөл боловсруулж байгаа газрууд барилгын сүлжээг байгуулах гээд ямар сүлжээгээр төлөвлөх вэ гэдэг асуудал яригддаг. Би өөрийнхөө компанийн сүлжээгээр төлөвлүүлчих юм сан гэж боддог, гэтэл тухайн сумд манай компанийн сүлжээ орсон эсэх нь тодорхойгүй. Тийм учраас тэдгээр хүмүүс байгаагаар нь төлөвлөнө гэдэг. Ерөнхийдөө IPTV сүлжээ орсон байна гэдэг. Сумдын өөрийн сүлжээ оруулсан газрыг хэрэв зээ нууц биш бол нийтэд мэдээлж байж болдоггүй юм уу. Тэгвэл зураг төслийн байгууллагууд энд сүлжээ орсон юм байна гээд хялбар болох юм биш үү. Бас үйлчилгээний хүрээг өргөтгөхөд нэмэр хандив болох юм биш үү гэж асуугаад байгаа. Гуравдугаарт материалд байхгүй байгаад байх юм. Хуучин Аудитын хорооны тайлан гээд жилийн тайланд гардаг байсан. Энэ дээр алга байна уу, эсвэл би үзсэнгүй юу, татаж авсан материалд байхгүй байсан. Энэ дээр ч алга байна. ТУЗ-ийн тогтоол Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэж гарсан юм байна гэж ойлголоо. Аудитын хорооны дүгнэлт байсан бол бидэнд үзэж харах хэрэг байсан болов уу гэж бодлоо.

Б.Чинбат, Гүйцэтгэх захирал: Би хоёр дахь асуултаас эхлэн хариулъя. 4,314 гэдэг тоо бол 2024 оны 12 сарын байдлаар FTTH сүлжээнд холбогдсон цэгийн тоо гэж ойлгож болно.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Цэгийн тоо юу уу, тэгэхээр 2024 онд 900 цэг холбосон байна гэж ойлгож болох уу. ONT-ээр нь яриад байна уу.

Б.Чинбат, Гүйцэтгэх захирал: Тэгж ойлгож болно. Энэ тоо өдрөөс өдөрт өөрчлөгдөж байгаа. 47 сум гэдэг нь 47 сумдад үндсэн сүлжээгээ байгуулсан. Тэндээс айл руугаа access сүлжээ оруулах боломжтой болсон.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Бусад сумдад хэрэглээ байхгүй байна уу, эсвэл бид хангаж чадахгүй байна уу.

Б.Чинбат, Гүйцэтгэх захирал: Хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаарлагдаж байгаа. Өнгөрсөн онд 47 байсан сумдын тоог энэ онд 80 гаргана гэсэн төлөвлөгөөтэй байна. Хоёрдугаарт Сүлжээ компанийн урсгалын хэмжээнд баригдаад байгаа. Хүссэн сумдаа оруулж чадахгүй, МХС компанийн урсгалын багтаамж хир боломжтой байгаагаас сумдын тоо хамаарч байгаа. Сүлжээ орсон сумдын мэдээлэлд нууцлал гэж байхгүй, Барилгын хөгжлийн төвтэй хамтарч ажиллаж байгаа.

Х.Баянбай, ТУЗ-ийн хараат бус гишүүн: Аудитын хорооны дүгнэлтийг бид 4 сарын 15-нд гаргаад ТУЗ-д хүргүүлсэн. Яагаад оруулаагүй бид мэдэхгүй. Тайлан бол энд байгаа шүү.

Ц.Баяр-Эрдэнэ, ТУЗ-ийн дарга: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаа танилцуулж байх үед зарим гишүүдээс санал гараад Компанийн тухай хууль болон дүрмийн зохицуулалтуудыг үндэслэн, хараат бус аудитын санал дүгнэлтийг үндэслэж Аудитын хороо санал дүгнэлтээ гаргаж ТУЗ-д танилцуулж байгаа учраас тусгайлан Аудитын хороо санал дүгнэлтээ хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах шаардлагагүй гэдэг санал гарч санал хураагаад шийдсэн дотоод хурлын процессын шинжтэй асуудал байгаа шүү. Яг Аудитын хорооны дүгнэлттэй тухайлан танилцана гэвэл одоо манай Аудитын хорооныхон санал дүгнэлтийг цаасаар өгч болно.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Аудит хороо компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой чухал зүйл бичсэн байдаг л даа. Тэндээс тодорхой дүгнэлт гардаг. Түүний биелэлтийг яаж хэрэгжүүлснийг компанийн тайланд гардаггүй. Зөндөө бичсэн байдаг. Шүүмжлэл дагуулаад байдаг гээд хассан юм уу гэдэг хардалт төрөөд байдаг. Зарим тийм байсан байна. Ойлголоо. E10 станц гэж бичээд байх юм. Буулгаад 4 жил болж байна. Одоо бол Soft switch байгаа. Мэргэжлийн байгууллагын тайлан учраас мэргэжлийн байх хэрэгтэй гэж хэлэх гээд байна.

Сайн-Ерөөлт: Үйл ажиллагаа явуулахад байшин хороололд үйл явуулахад СӨХ маш асуудал байдаг. Төр төлөөлөөд сууж байгаа хүмүүсээс асуухад СӨХ-ийн зөвлөлтэй ямар холбоотой байдаг вэ. Нэг гэмтэл саатал эсвэл сүлжээ дэлгэрүүлэхээр СӨХ гаргадаггүй. Гэрээ хий, өндөр төлбөр нэхдэг. Юнивишн ихэнх хувийг нь эзэлж байгаа тул өндөр төлбөр төлдөг. Манай компани цөөн хэрэглэгчийн гэмтэл саатал засах тохиолдолд өндөр төлбөр төлөхөд ашиггүй болдог. СӨХ-үүдийн зөвлөлтэй ямар харилцаа холбоотой хамааралтай байдаг вэ. Шонгийн модоор татсан кабелийг 8 сараас Нийслэлийн засаг дарга маань хайчлаад эхлэх гэж байна. Энэ бол маш зөв асуудал, баяртай байна. Гуравдугаарт МХС компанитай өрийн асуудал орон нутгийн холбоодын байруудыг өгсөн, өнөө байр нь сардаа 5 сая төгрөгийн орлого олдог гэсэн, үүнд тайлбар өгнө үү.

Ц.Баяр-Эрдэнэ, ТУЗ-ийн дарга: СӨХ-ын дээд зөвлөлтэй хамтарч ажиллах талаар хаана хаанаасаа санал гаргаад ажиллах асуудал. Төрийн байгууллагуудын хувьд СӨХ-ын дээд зөвлөлтэй шууд холбогдох тогтолцоо, хууль эрх зүйн боломж байхгүй л дээ. Одоо бол СӨХ-ын хууль явж байгаа. Хуульд тодорхой зохицуулалтууд орж байгаа юм билээ. СӨХ гэдэг бол бие даасан, тухайн орон сууцанд амьдарч байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалсан олон нийтийн байгууллага болоод байгаа. Таны саналаар төрийн байгууллагын чиглэлээр компаниас тавьж байгаа саналыг СӨХ-ын дээд зөвлөл дээр очиж ажил хэргийн уулзалт хийгээд СӨХ-д тэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг. Шууд удирдлагаар

хангадаггүй. СӨХ-д тодорхой ажиллах санал оруулдаг юм уу, хамтын ажиллагааны харилцан уялдаа холбоо үүсгээд ажиллавал компанийн үйл ажиллагаанд хэрэгтэй байх. Түүнийг бол ажил болгох хэрэгтэй. Хамтын ажиллагааны асуудлыг хүргүүлэхэд бид дэмжээд ажиллах бололцоотой.

Б.Чинбат, Гүйцэтгэх захирал: Wifi бол санал гэж ойлгосон. Энэ жилийн сумдад хэрэгжүүлэх төслүүдэд WiFi технологио түлхүү хэрэглэе гэсэн бодолтой байгаа. Тэнд зардал, суурилуулалт 40 хувиар, цаг хугацаа хэмнэгдэж байгаа. Гэмтэл саатал мөн бага байгаа. МХС компанитай хөрөнгө шилжүүлсэн асуудалтай холбоотой сард 4-5 сая төгрөг олдог объектоо шилжүүлсэн тохиолдолд байхгүй. Ямар объектыг ярьсан юм бол, зардал их гардаг, хөрөнгө оруулалт шаардлагатай объектуудаа шилжүүлсэн, тодорхой тийм аймгийн тийм сумын объект гээд тодорхой асуувал хариулж болж байна .

Ж.Баасандорж, хурлын дарга: Өөр асуулт, саналтай хувьцаа эзэмшигч байна уу.

Ж.Баасандорж, хурлын дарга: Асуулт саналтай хүн байхгүй байна. Тооллогын комисс санал хураалтаа явуулъя.

Т.Бямбасүрэн, Тооллогын комиссын дарга: Санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 24,503,286 ширхэг хувьцаа эзэмшиж буй 26 хувьцаа эзэмшигч оролцож, үүнээс 24 хувьцаа эзэмшигч санал өгсөн бөгөөд хүчингүй саналын хуудас 2 байна.

Саналын хуудсанд 4 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр доорх санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд

Зөвшөөрсөн 23 санал, 99.99 хувиар буюу 24,503,239 ширхэг хувьцаа; Татгалзсан санал байхгүй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай асуудалд Зөвшөөрсөн 23 санал, 99.99 хувиар буюу 24,503,239 ширхэг хувьцаа; Татгалзсан санал байхгүй.

3. Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний аргачлал батлах тухай асуудалд

Зөвшөөрсөн 23 санал, 99.99 хувиар буюу 24,503,239 ширхэг хувьцаа; Татгалзсан санал байхгүй.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудалд гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар санал өгснөөс;

ТУЗ-ийн ердийн гишүүнд

- | | |
|------------------|---|
| 1. А.Молор | 24,502,967 хувьцааны санал, 99.99 хувь; |
| 2. Ц.Баяр-Эрдэнэ | 24,501,106 хувьцааны санал, 99.99 хувь; |
| 3. Б.Төрбат | 24,501,121 хувьцааны санал, 99.99 хувь; |

- | | |
|--------------------|---|
| 4. Д.Нарангэрэл | 24,501,162 хувьцааны санал, 99.99 хувь; |
| 5. С.Ганзориг | 24,501,321 хувьцааны санал, 99.99 хувь; |
| 6. Б.Билэгдэмбэрэл | 24,501,106 хувьцааны санал, 99.99 хувь; |

ТУЗ-ийн хараат бус гишүүнд

- | | |
|------------------|---|
| 1. С.Цолмон | 24,501,106 хувьцааны санал, 99.99 хувь; |
| 2. Х.Баянбай | 24,500,411 хувьцааны санал, 99.99 хувь; |
| 3. Н.Туул | 24,500,236 хувьцааны санал, 99.99 хувь; |
| 4. Н.Улаанхүү | 2,788 хувьцааны санал, 0.0029 хувь; |
| 5. Н.Данзандагва | 710 хувьцааны санал, 0.0029 хувь; |

МЦХ ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99,99 (хувь)-ийн саналаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 99,99 (хувь)-ийн саналаар, Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний аргачлал батлах тухай асуудлыг 99,99 (хувь)-ийн саналаар тус тус баталж, кумулятив аргаар хамгийн өндөр санал авсан А.Молор, Ц.Баяр-Эрдэнэ, Б.Төрбат, Д.Нарангэрэл, С.Ганзориг, Б.Билэгдэмбэрэл нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнээр, С.Цолмон, Х.Баянбай, Н.Туул (тус бүр 99,99%) нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгох нь зүйтэй гэж үзсүгэй.

Ж.Баасандорж, хурлын дарга: Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолууд албажин гарна. Ингээд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч батлав.
2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолтой танилцав.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов. Үүнд:
 - Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Х.Баянбай, С.Цолмон, Н.Туул нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, Ц.Баяр-Эрдэнэ, А.Молор, Д.Нарангэрэл, Б.Билэгдэмбэрэл, Б.Ганбат, С.Ганзориг нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс тус тус сонгов.
 - Н.Норовжамцыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.

- Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг хавсралтаар батлав.
- Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.

6. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний аргачлал, загвар батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлалыг хавсралтаар батлав.

ТАНИЛЦСАН:



Ж.БААСАНДОРЖ, 2025 ОНЫ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Х.ЦЭЦЭГМАА, ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

2025 оны 5 дугаар сарын 02
Улаанбаатар хот.